

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.10.13

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Ерөнхийлөгч Трамп БНХАУ-аас импортлогдох бүх бараанд 100%-ийн нэмэлт тариф ногдуулах, мөн үндэсний аюулгүй байдлын үүднээс АНУ-д үйлдвэрлэсэн зарим программ хангамжийн экспортод хяналт тогтоох төлөвлөгөөгөө зарласантай.
- Уламжлалт ёсоор энэхүү улирлын эхлэлийг JPMorgan Chase-ийн 10 дугаар сарын 14-нд гарах тайлан эхэлнэ.
- Хүү бууруулахыг болгоомжтой дэмжив. АНУ-ын засгийн газрын үйл ажиллагааны зогсолт үргэлжилж, гол эдийн засгийн мэдээллүүд гараагүй байгаа нөхцөлд хөрөнгө оруулагчид анхаарлаа Холбооны нөөцийн (Fed) 9 дүгээр сарын бодлогын хуралдааны тэмдэглэл рүү хандууллаа.
- Бодлогын түвшинд анхаарал татаж буй дараагийн чухал үйл явдал бол 10-р сарын 20-23-нд болох Хятадын Коммунист намын IV хурал (Fourth Plenum) юм.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Таамагласан ханшид хүрсэн.
Дээд таамаглал **7,000** байна





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.10.06-10.12

АНУ-ЫН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД УНАЛТТАЙ ХААГДЛАА

Өнгөрөгч баасан гарагт АНУ-ын хөрөнгийн зах зээл сүүлийн зургаан сарын хугацаан дахь хамгийн хүчтэй уналтаа үзүүллээ. Ерөнхийлөгч Трамп БНХАУ-аас импортлогдох бүх бараанд 100%-ийн нэмэлт тариф ногдуулах, мөн үндэсний аюулгүй байдлын үүднээс АНУ-д үйлдвэрлэсэн зарим программ хангамжийн экспортод хяналт тогтоох төлөвлөгөөгөө зарласантай холбоотой АНУ-ын голлох хөрөнгийн индексүүд Баасан гарагт огцом унасан. Dow Jones Industrial Average 1.9%-иар, S&P 500 2.7%-иар, NASDAQ Composite 3.6%-иар тус тус буурсан.

Nasdaq Composite болон S&P 500 индексүүд долоо хоногийн эхний 4 өдөр өсөлттэй байсан бөгөөд хиймэл оюун ухаанд (AI) хамаарал бүхий компаниудад чиглэсэн хүлээлт өндөр хэвээр байв. Үүнд хэд хэдэн шинэ стратегийн хамтын ажиллагааны мэдээ, тухайлбал Advanced Micro Devices (AMD) болон OpenAI-ийн түншлэл, AMD-ийн хувьцаа Даваа гарагт 20 гаруй хувиар өсөхөд хүргэв. Гэвч Баасан гарагийн өглөө Ерөнхийлөгч Дональд Трамп нийгмийн сүлжээнд “Хятадын бараанд тарифийг асар ихээр нэмэгдүүлэнэ” хэмээн бичсэний дараа хөрөнгийн зах зээл огцом унав. Энэ нь БНХАУ газрын ховор элементийн экспортоо хязгаарлах шинэ журам санаачилсны хариуд хийгдсэн мэдэгдэл байв. Үүнтэй зэрэгцэн алтны ханш түүхэн дээд түвшинд хүрч, анх удаа унц нь 4,000 ам.долларыг даван өссөн нь геополитик болон эдийн засгийн тодорхойгүй байдал өндөр хэвээр байгааг харууллаа.

Хөрөнгө оруулагчид мөн гуравдугаар улирлын орлогын тайлан эхлэхийг хүлээж байгаа нь анзаарагдаж байв. Уламжлалт ёсоор энэхүү улирлын эхлэлийг JPMorgan Chase-ийн 10 дугаар сарын 14-нд гарах тайлан эхэлнэ. Засгийн газрын үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор голлох эдийн засгийн үзүүлэлтүүд гарч чадахгүй байгаа энэ үед компанийн ашиг орлогын тайлангууд зах зээлд болон хөрөнгө оруулагчдын сэтгэлзүйд илүү том нөлөө үзүүлэх хандлагатай байна. FactSet-ийн судалгаагаар S&P 500 индекс ес дэх улиралдаа дараалан ашиг үзүүлэлт өсөлттэй гарах төлөвтэй байна.

Холбооны нөөцийн тайлан: Хүү бууруулахыг болгоомжтой дэмжив. АНУ-ын засгийн газрын үйл ажиллагааны зогсолт үргэлжилж, гол эдийн засгийн мэдээллүүд гараагүй байгаа нөхцөлд хөрөнгө оруулагчид анхаарлаа Холбооны нөөцийн (Fed) 9 дүгээр сарын бодлогын хуралдааны тэмдэглэл рүү хандууллаа. Тус тэмдэглэлд бодлого боловсруулагчид эдийн засгийн эсрэг чиглэлтэй дохио зангааг дүгнэж, байр суурийн зөрүүтэй байгааг харуулжээ. Тэд өндөр түвшинд хадгалагдаж буй инфляци болон суларч буй хөдөлмөрийн зах зээлд санаа зовниж, “инфляцийн өсөлтийн эрсдэл өндөр хэвээр байгаа бөгөөд ажил эрхлэлтийн буурах эрсдэл нэмэгдсэн” гэж тэмдэглэжээ.

Эцэст нь, ихэнх бодлого боловсруулагчид энэ оны үлдсэн хугацаанд мөнгөний бодлогыг цаашид зөөлрүүлэх нь зүйтэй гэж үзсэн бол зарим нь одоогийн бодлого харьцангуй чанга биш хэмээн үзэж, ирээдүйн бодлогын шийдвэрийг болгоомжтой авч үзэх шаардлагатай хэмээн дүгнэжээ.

 Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.10.06 – 10.12

БНХАУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ХОЛИМОГ ХӨДӨЛГӨӨНИЙГ ҮЗҮҮЛЛЭЭ

БНХАУ-ын хөрөнгийн зах зээл амралтын дараах богино долоо хоногийг холимог байдлаар өндөрлөлөө. Дотоодын гол үзүүлэлт болох CSI 300 индекс 0.51%-иар буурч, харин Шанхайн нийлмэл индекс 0.37%-иар өссөн байна. Хятадын хөрөнгийн биржүүд 10-р сарын 1-нээс эхэлсэн 8 өдрийн амралтын дараа 10-р сарын 9-ний Пүрэв гарагт дахин нээгдсэн юм. Харин Гонконгийн Hang Seng индекс FactSet-ийн мэдээлснээр 3.13%-иар унажээ.

Эхний тоон мэдээллээс үзэхэд, Хятадын “Алтан долоо хоног”-ийн үеийн хэрэглээ 5-р сарын Хөдөлмөрийн баярын тав хоногийн амралтын үеийн идэвхжилээс сул байсан байна. Bloomberg агентлагийн мэдээлснээр, жижиглэн худалдаа болон зоогийн газрын борлуулалт “Алтан долоо хоног”-ийн эхний хагаст 3.3%-иар өссөн нь Хөдөлмөрийн баярын үеийн өсөлтийн хагас хувьтай тэнцжээ. Харин Зам тээврийн яамны урьдчилсан тооцоогоор зорчигчдын дундаж хөдөлгөөн өнгөрсөн жилийнхээс 6.2%-иар өссөн нь мөн өмнөх амралтын 8%-ийн өсөлтөөс доогуур дүн гарсан байна.

Эдгээр сул хэрэглээний үзүүлэлт нь Хятадын хувьд дотоодын хэрэглээ идэвхждэг оргил үед тооцогддог “Алтан долоо хоног”-ийн үеэр ажиглагдсан нь, Бээжингийн эдийн засгийг үйлдвэр, экспортод төвлөрсөн бүтцээс дотоодын хэрэглээ ба үйлчилгээний салбарыг дэмжих чиглэлд шилжүүлэх бодлогын сорилтыг илтгэж байна.

Бодлогын түвшинд анхаарал татаж буй дараагийн чухал үйл явдал бол 10-р сарын 20-23-нд болох Хятадын Коммунист намын IV хурал (Fourth Plenum) юм. Уг хурлын үеэр удирдлагуудаас дэвшүүлсэн дараагийн таван жилийн төлөвлөгөөний төсөл, өөрөөр хэлбэл улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг хэлэлцэж батлах хүлээлттэй байна. Шинжээчид хурлын дараах албан мэдэгдэл, илтгэлийг анхааралтай ажиглаж, Хятадын эдийн засгийн бодлогын чиглэлд ямар өөрчлөлт гарах талаар баримжаа авч магадгүй гэж үзэж байна.

Golomt_Capital created with TradingView.com, Oct 13, 2025 11:17 UTC+8

Hang Seng Index Futures - 1W - HKEX | O26,280 H26,440 L24,968 C25,696 -587 (-2.23%) -587 (-2.23%)



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
STZ Constellation Brands	AEHR AEHR TEST BY SYSTEMS	MKC McCormick	PENG PENGUIN SOLUTIONS SAR SARATOGA INVESTMENT CORP.	AZZ AZZ RGP RGP BSET Bassett RELL Richardson Electronics	DAL DELTA PEP PEPSICO BYRN byrna TLRY TILRAY HELE Helen of Troy NEOG NEOGEN	APLD APPLIED BLOCKCHAIN APOG apogee enterprises, inc. LEVI Levi's		
http://eps.sh/cal						© 2025 Earnings Whispers		

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
FAST FASTENAL		BLK BlackRock JPM JPMORGAN CHASE & CO. GS Goldman Sachs C citi WFC WELLS FARGO JNJ Johnson & Johnson DPZ Dorland ERIC ERICSSON ACI Albersons Computers BCE BCE	KARD KAROO000 HWC HILTI EQBK EQUITY BANCSHARES, INC.	ASML BAC BANK OF AMERICA DLTR DOLLAR TREE PGR PROGRESSIVE SYF synchrony MS Morgan Stanley ABT Abbott PLD PROLOGIS FHN FIRST HORIZON NATIONAL CORPORATION CFG Citizens Financial Group, Inc.	DAL UNITED JBHT J.B. HUNT HOMB HOMER PNFP Pinnacle Financial BANR ANNER BANK SNV SYNOVUS REXR REXR Roxford Industrial SLG ISL GREEN REALTY CORP. FR FIRST INDUSTRIAL REALTY TRUST GSBC GREAT SOUTHERN BANK	TSMC tsmc BKJ BNY KEY KeyBank INFY Infosys SCHW charles SCHWAB TRV TRAVELERS CMC Commercial Metals MTB M&T Bank SNA Snap-on USB usbancorp	IBKR Interactive Brokers CSX [CSX] SFNC Simmons Bank GBCI GLACIER BANK FNB First National Bank OZK BankOZK LBRT LIBERTY INDB INDEPENDENT CNS COHEN & STEERS	SLB slb ALLY ally FITB FIFTH THIRD BANK STT STATE STREET AXP AMERICAN EXPRESS TFC TRUIST ALV Autoliv HBAN Huntington CMA Comerica RF REGIONS
http://eps.sh/cal						© 2025 Earnings Whispers		